



# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**  
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА

БАЯНХОНГОР АЙМАГ  
2025.03.10

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН  
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА В.БАТЖАРГАЛ НАРЫН  
2025 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 03 дугаар сарын 10

Дугаар 2025/08

Номгон

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Гэрээний зорилго нь **Баянхонгор аймгийн Засаг дарга Баянговь сумын Засаг даргын** хооронд үүсэх эрх, үүрэг, гүйцэтгэх ажил үйлчилгээ, түүний тоон болон чанарын үзүүлэлт, хүрэх үр дүн, төсвийн санхүүжилтийг тодорхойлох гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тавигдах шаардлага, гэрээг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төсвийн тухай хуулийн 40 дүгээр заалтыг үндэслэн энэхүү гэрээг нэг талаас **Баянхонгор аймгийн Засаг дарга Долгорсүрэнгийн Мөнхсайхан**, нөгөө талаас **Баянговь сумын Засаг дарга Ванданхүүгийн Батжаргал** нар 2025 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал нэг жилийн хугацаатайгаар байгуулж 2 хувь үйлдэв.

1.3. Уг гэрээнд аймгийн Засаг даргаас төлөөлөн гүйцэтгэх, сумын Засаг даргын чиг үүрэг, ажил үйлчилгээг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүргэж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ түүний зардлын санхүүжилт, талуудын хүлээх үүрэг, гэрээний биелэлтийг тайлагнах, дүгнэх зэрэг гэрээний нөхцөлийг тусгав.

1.4. Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хооронд байгуулсан гэрээтэй холбогдох харилцааг төрийн албаны тухай хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны хууль, Нягтлан бodoх бүртгэлийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад салбарын үйл ажиллагааг зохицуулах болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.5. Хавсралт энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

**Хоёр. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг**

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч болох аймгийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ.

2.2. Тухайн сумд гүйцэтгэх ажлыг худалдаж авахад 898,401.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн санд 1,366,325.2 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгоно. /Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэгчийг шалгаруулах тендерээр авсан үнийн дүнгийн хэмжээгээр санхүүжилт олгоно./

2.3. Гэрээний нөхцөл болон ажил үйлчилгээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд зохицуулах, дэмжлэг үзүүлэх, арга хэмжээг авч, харилцан уялдаатай ажиллах.

2.4. Сумын Засаг даргаас гүйцэтгэх үйл ажиллагааны үр дүнгийн талаарх эцсийн хариуцлагыг аймгийн Засаг дарга ажлаа тайлагнадаг дээд шатны байгууллага болох Засгийн газрын өмнө хариуцна.

2.5. Санхүүжилтийн хуваарьт шаардлагатай тохиолдолд сар улирлаар зохицуулалт хийж болно.

#### **Гурав. Сумын Засаг даргын хүлээх үүрэг**

3.1. Сумын Засаг дарга нь гэрээнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаж, заалт бүрийг зорилтот түвшинд хүргэж хэрэгжүүлэхэд анхаарч, зохион байгуулалтыг шуурхай удирдлагаар хангаж, гүйцэтгэлийг үнэлж, үр дүнг тайлагнаж, аймгийн Засаг даргын өмнө хариуцах.

3.2. Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж, орлогыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг татаж, төсвийн сахилга батыг хянаж, зөрчилгүй ажилласан байх.

3.3. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын байрны дэг журам, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, ашиг сонирхол, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх.

3.4. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшнийг бууруулж, Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангаж ажиллах.

3.5. Аймаг орон нутагт хэрэгжиж байгаа дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлж, салбарын удирдлагуудтай нягт уялдаа холбоотой хамтран ажиллах.

3.6. Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтворт суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх, төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэж ажиллах

3.7. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам шинэчлэн батлах тухай” журмын хэрэгжилт, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай зохион байгуулж, хяналт шинжилгээ үнэлгээний дүнг өмнөх оноос ахиулсан байх

3.8. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж

ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;

#### **Дөрөв. Улсын төсвийн санхүүжилт**

4.1.Сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилт нь төсөв батлах тухай, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан тухайн оны төсөв байх бөгөөд түүний санхүүжилтийг хуваарийн дагуу төрийн сангаар дамжуулан гүйцэтгэх.

4.2.Сумын төрийн сан төсөвт байгууллагын санхүүжилтийг төсвийн дансанд ажлын нэг хоногт баатарын шилжүүлэх.

4.3.Аймгийн Засаг даргын нэрийн өмнөөс сумын Засаг даргын гүйцэтгэх ажлын санхүүжилтийн төлбөрийг аймгийн Засаг даргатай тохиролцсон хуваарийн дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст шилжүүлнэ. Энэ тохиолдолд 4.2, 4.3 дахь заалт нэгэн адил хүчинтэй тооцох.

4.4.Төсвийн тухай хуулийн 41.1 , 41.2 дугаар зүйлд заасны дагуу сумын Засаг даргаас эрхлэн гаргасан сар бүрийн санхүүгийн тайлан, улирал бүрийн эцэст төсвийн хуваарилалт, зарцуулалт, бүрдүүлэлтэд хяналт тавьж тайлан гаргаж аймгийн Засаг даргад хүргүүлэх.

4.5.Сумын Засаг дарга хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол аймгийн Засаг дарга түүний төлбөрийг хийх үүрэг хүлээхгүй. Ирүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний тайландаа хийсэн үнэлгээгээр гэрээнд хийсэн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаагүй бол дараагийн улирал, жилийн хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний төлбөрийг зохих журмын дагуу бууруулан зохицуулалт хийх.

4.6.Сумын санхүүгийн албаны дарга төрийн сангийн мэргэжилтэн болон төсвийн нягтлан бодогчдыг томилж чөлөөлөхдөө аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй зөвшүүлэлтэй Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөх.

4.7.Улс аймаг, сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, улс аймгийн төсвийн орлогод төвлөрүүлэх орлогыг цаг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх.

4.8.Сумын Засаг дарга нь төсөв болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу Санхүү төрийн сангийн хэлтэст ирүүлэх.

#### **Тав.Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээг дүгнэх**

5.1.Гэрээний биелэлтийг хавсралтад заасан хэрэгжүүлэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу хурсэн түшингийн үр дүнг журмын дагуу хэрэгжилтийг хагас жилээр 2024 оны 06 дугаар сарын 15-нд , жилийн эцсийн хэрэгжилтийг 12 дугаар сарын 15-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаа хоцроолгүй тайлагнана.

5.2.Хамтран ажиллах гэрээг Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлага хангаж, дээд газрын буюу Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн үнэлгээгээр хэрэгжилтийн товчоо үйлдэж, холбогдох эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг дарж, баталгаажуулж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тухайн оны дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор цаасаар ирүүлнэ.

5.3.Сумын Засаг даргын хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний тайланд дүгнэлт хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.4.Шаардлагатай бол тусгайлсан мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэнэ.

#### **Зургаа . Гэрээгээр харилцан хүлээх үүрэг**

6.1.Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2.Төрийн албаны тухай, Төсвийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн заалтуудыг баримтлан ажиллана.

6.3.Гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж, хугацаа хожимдуулах тасалдуулах зэрэг алдаа дутагдал гаргахгүй ажиллана.

6.4.Шаардлага гарсан нөхцөлд харилцан зөвшилцсэний үндсэн дээр гэрээг цуцалж болно.

#### **Долоо.Маргааныг шийдвэрлэх**

7.1.Гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох үүссэн маргааныг шийдвэрлэхдээ:

7.2.Хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээтэй холбогдон үүссэн асуудлыг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэж байна.

7.3.Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг аймгийн Засаг даргын Тамгын газарт хандаж зохицуулах арга хэмжээ авхуулна.

7.4.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зөвлөгөө авч ажиллана.

#### **Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

8.1.Гэрээ байгуулснаас хойш эхний зургаан сард, сүүлийн зургаан сард биелэгдэхүйц нэмэлтээр ажил арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг тооцож болно.

8.2.Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.3.Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь хийж, талууд гарын үсэг зурж гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг хадгална.

8.4.Гэрээнд тусгагдаагүй чиг үүрэг, ажил үйлчилгээг талууд харилцан зөвшилцж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх болно.

### Ес. Гэрээний хариуцлага

9.1. Сумын Засаг дарга гэрээний хавсралтад тусгагдсан үүргийг хангалттай биелүүлсэн тохиолдолд аймгийн төсвийн өрөнхийлөн захирагч хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага, урамшууллыг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

9.2. Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгавар, хариутай албан бичиг, мэдээ тайланг хугацаанд нь шаардлагын дагуу гаргаж ирүүлэх, биелүүлээгүй тохиолдолд Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.





Аймгийн Засаг дарга сүмүн Засаг даргатай 2025 онд  
хамтран ажиллах гэрээний нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА СҮМҮН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН  
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ  
АРГА ХЭМЖЭЭ**

№	Зорилт арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Сурь түшин	2025 онд хүрэх түвшин
1	2	3	4	5
<b>1. Төрийн захиргаа, удирдлага зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд</b>				
1.1	Шинээр санаачилсан арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	-	100
1.2	Нутгийн захиргааны байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ	Ерөнхий үнэлгээний өсөлтийн хувь	80.25	81.25
1.3	Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах	Гэрээний хэрэгжилтийн хувь	96.19	97.19
1.4	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, улирал бүр тайлагнах	Шийдвэрлэлтийн хувь	80	95
1.5	Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	Бэлтгэл ажлын хувь	0	70
<b>2. Гадаад харилцааны ажлын хүрээнд</b>				
2.1	Сумын түвшинд хэрэгжүүлэх гадаад айлчлал, арга хэмжээ, уулзалт, байгуулах баримт бичгийн талаар удирдамж, чиглэл авч, илтгэх хуудас, ярианы тэмдэглэлийг хүргүүлж байх	Удирдамжийн тоо	0	1
		Илтгэх хуудас, ярианы тэмдэглэлийн тоо	0	1
		Санамж бичиг, гэрээний тоо	0	1
<b>2.Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хүрээнд</b>				
3.1	Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	Сургалтын давтамжийн хувь	70	95
		Албан хаагчдын ур чадварын хувь	70	95
		Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	70	95
3.2	Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ажиллах орчин нөхцөлийн сайжралтын хувь	50	70
		Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	60	80
		Цалин хангамжийн өсөлтийн хувь	90	95
3.1	Хүний нөөцийн судалгаа хийх	Хэрэгцээтэй хүний нөөцийн судалгаа \Эрэлт нийлүүлэлт\	0	1
		Оюутны сурагчдын судалгаа	0	1
3.4	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх	Дэд хорооны ажлын гүйцэтгэлийн хувь	0	100

1	2	3	4	5
<b>4. Байгууллагын ил тод байдлын хүрээнд</b>				
4.1	Төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж, шилэн индексийн тайланг ( <a href="http://shilen.gov.mn">shilen.gov.mn</a> )-д улирал бүр илгээж, үнэлгээ хийлгэх	“Shilen.gov.mn” нэгдсэн системийн үнэлгээний хувиар	90.20	100
4.2	Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах, тогтмол шинэчлэх	Хэрэгжилтийн хувь	-	50
4.3	Иргэдийн сэтгэл ханамжийн <a href="http://Irgen.Bayanhongor.gov.mn">Irgen.Bayanhongor.gov.mn</a> нэгдсэн системийн судалгаанд иргэдийг хамруулах, систем ашиглалтыг нэмэгдүүлэх	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	712	600 дээш
<b>5. Албан хэрэгцээний систем ашиглалтын хүрээнд</b>				
5.1	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ тогтолцоонд шилжиж, албан бичгийг кирилл болон үндэсний бичгээр хөтөлж хэвших	Зохион байгуулсан сургалтын тоо	1	4
		Албан хаагчдын ур чадварын хувь	20	80
		Монгол бичгээр явуулсан албан бичгийн хувь	50	100
5.2	Албан бичгийн эргэлтийн “ERP” системийг албан хэрэгцээнд бүрэн ашиглаж хэвших	Ирсэн бичгийн бүртгэлийн хувь	50	100
		Явсан бичгийн бүртгэлийн хувь	60	100
		Хугацаатай албан бичгийн хаалтын хувь	50	100
		Бичиг хэргийн ажилтны систем ашиглалтын хувь	30	90
		Гүйцэтгэх ажилтны систем ашиглалтын хувь	30	90
		Удирдах ажилтны систем ашиглалтын хувь	30	90
5.3	Албан бичиг боловсруулалтын e-office системийг бүрэн ашиглаж хэвших	Боловсруулсан албан бичгийн хувь	50	100
		Бичиг хэргийн ажилтны систем ашиглалтын хувь	30	90
		Гүйцэтгэх ажилтны систем ашиглалтын хувь	30	90
		Удирдах ажилтны систем ашиглалтын хувь	30	90
<b>6. Гамшигийн үеийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд</b>				
6.1	Гамшигийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, нэгдсэн дадлага сургууль зохион байгуулах	Хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	3 200	5 400
6.2	Сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах томилгоот мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургах,	Нийт хүн амын хамрагдалтын хувь	50 0	100 80

1	2	3	4	5
	чадавхжуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах	Эрсдэлийн үнэлгээ		
<b>7.Хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд</b>				
7.1	Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх	Сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо Сурталчилгааны тоо	10 0	1000 50
7.2	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх	Захиргааны хэм хэмжээний актын тоо	-	2
7.3	Иргэд, хуулийн этгээдэд тоон гарын үсэг олгох ажлыг сумын хэмжээнд эрчимжүүлэх	Цахим гарын үсгийн олголтын хувь	-	80%
7.4	УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтооолоор батлагдсан "Хүний эрхийн үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2023 оны 357 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төлөвлөгөө, Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтооолоор батлагдсан төлөвлөгөөний хамаарал бүхий заалтын хэрэгжилтийг ханган ажиллах	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	100
7.5	Хэрэглэгчийн эрхийн хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтыг зохион байгуулсан тоо	-	5
7.6	Гэмт хэрэг, зөрчлийн тоог буурсан байх	Гэмт хэрэг, зөрчлийн тоог 1 нэгжээр буурсан үзүүлэлт	2	1
7.7	Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг архины эмчилгээнд хамруулж, ажлын байраар хангах	Архинаас гарсан иргэний тоо ажлын байраар хангагдсан иргэний тоо	0 0	3 1
7.8	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллах	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	4
7.9	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Гэр бүлийн хүчирхийлэлэс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	4
7.10	Мал хулгайллах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж, малчдын булгийн	Мал хулгайллах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	Тухайн сумд үйлдэгдсэн	5

1	2	3	4	5
	үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байх	зохион байгуулсан арга хэмжээний тоо	мал хулгайлах гэмт хэргийн гаралтын тоо	
7.11	Хууль тогтоомжоор тогтоосон сумын Засаг даргын эрх хэмжээний асуудлаар аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, сумын Хэсгийн төлөөлөгчтэй гурвалсан гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр биелэлтийг тооцож ажиллах	Гэрээний биелэлтийн хувь	-	100
7.12	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтийг хангаж, үр дүнд хүргэж ажиллах	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	100 хувь	100 %
7.13	Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай хуульд заасан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах	Гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь	-	1 нэгжээр бууруул ах
7.14	Ажилтан бүрийн ажлын үр дүнг улирал, хагас, бүтэн жилээр дүгнэж урамшуулалт олгохдоо албан хэргийн баримтжуулалт, стандарт хангалт, мөн заасан хугацаанд байгууллагын архивд баримтаяа эмхлэн цэгцэлж цахим хувьтай бүрэн шилжүүлсэн байдал зэргийг харгалzan дүгнэж хэвших	Ажилтан бүрийн баримтжуулалт, боловсруулалт, стандарт шаардлага хангалтын хувь Ажилтан бүрийн архивд баримтаяа /цахим хувь/ бүрэн бүрдэлтэй шилжүүлсэн баримын хувь	0 0	100 100
7.15	“Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах 2023-2027 оны бодлого чиглэл”-ийг харьяа байгууллагууддаа хэрэгжүүлэх	Сумын төсөвт 6 байгууллагын нягтрнуулсан тавиур шүүгээний тоо Сумын төсөвт 6 байгууллагын хамгаалах хайрцагны тоо	Тухайн сумын 2024 оны жилийн эцсийн үзүүлэлт	1-3 20
7.16	Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтын талаарх 2025-2028 оны аймгийн бодлого чиглэлийн хэрэгжилтийг хангаж байгууллагуудын үндсэн 2022 оны болон урьд шилжүүлээгүй тасалсан бусад оны баримтыг Төрийн архивд цаасан болон цахим хэлбэрээр дансны хамт бүрэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих	Сумын төсөвт 6 байгууллагын 2022 оны архивын баримтыг шилжүүлэлтийн хувь Сумын төсөвт 6 байгууллагын тасарсан /өртэй/ бусад оны баримтаяа цахим болон цаасан хувиар бүрэн Төрийн архивд шилжүүлсэн шилжүүлэлтийн хувь	Тухайн сумын 2024 оны жилийн эцсийн үзүүлэлт	100 100

1	2	3	4	5
7.17	"Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчинээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх бодлого чиглэл"-ийг хэрэгжүүлэх, архив бичиг хэргийн мэргэжилтэй, ажилтныг дэмжих, тогтвортсуурьшилтай ажиллуулах орон нутгийн нэмэгдэл 80 хүртэлх хувиар олгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	Сумын төсөвт 6 байгууллагын бодлого чиглэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь  Сумын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтныг нэмэгдлийн хувь-50-80	Тухайн сумын 2024 оны жилийн эцсийн үзүүлэлт	100  50-80
<b>8. Боловсролын салбарын хүрээнд</b>				
8.1	Иргэнд тэгш хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэх /хавсралтаар/	Хавсралтад заасан хүрэх түвшний гүйцэтгэлийн хувиар	-	100
<b>9. Эрүүл мэндийн салбарын хүрээнд</b>				
9.1	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг дэмжин ажиллаж, иргэдэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь	52.1	80
9.2	Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн шүдний өвчлөлийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч, Ерөнхий боловсролын сургуулийн 4,5,6 дугаар ангийн хүүхдүүдийн дунд "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Эрүүлжүүлэлтийн хувь  9-12 насын хүүхдүүдийн хамралтын хувь	17.9  -	90  100
9.3	Эх, нялхас, 5 хүртэлх насын хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг туштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусlamж үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулах, хяналт тавих	Эндэгдлийн тоо	1	0
9.4	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ хэрэгжүүлж, халдварт өвчиний тохиолдлыг бууруулах	Халдварт өвчний тохиолдлын тоо  Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	24  90	20  95
9.5	"Эрүүл Монгол Хүн" үндэсний хөдөлгөөн, "Эрүүл иргэн-Хонгорын баялаг" 2023-2026 арга хэмжээг сум орон нутагтаа өрнүүлэх, олон нийтэд "Эрүүл амьдралын хэв маяг" төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөн, зөв зохистой хооллолтыг дэмжих, архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, Монгол хүнийг өвчлөхөөс уртаж урьдчилан	Архи, тамхи хорт зурслын хэрэглээнээс татгалзсан иргэдийн тоо  Иргэдэд чиглэсэн цогц арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-  93	10  95

1	2	3	4	5
	сэргийлэлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх			
9.6	Иргэд олон нийтэд архины хамаарлын хор уршиг, түүнээс сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, төсөв хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Зарцуулсан төсвийн хэмжээ, хувь	-	Гүйцэтгэ лээр
9.7	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутан залуусын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо	297	447
9.8	Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгаа бусад арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо  Хамрагдсан иргэдийн тоо	-  -	10  650
9.9	MNS6392:2013 "Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага", MNS7014:2023 "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" стандартуудын хэрэгжилтийг хангаж, эрүүл мэндийн барилга байгууллагын ашиглалтад хяналт тавих, шаардлагатай урсгал болон их засварт дэмжлэг үзүүлэх	Зарцуулсан төсвийн хэмжээ  Стандарт мөрдөлтийн хувь	-  80.5	Гүйцэтгэ лээр  90
9.10	ЭМС-ын 2024 оны "Хүний папиллома вирусийн /ХПВ/ халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/455 дугаар тушаалыг хэрэгжүүлж, вакцины хамралтад хяналт тавьж, эрчимжүүлж ажиллах	ХПВ вакцины хамралтын хувь	40.3	90
9.11	0-5 хүртэлх насын хүүхдийн өсөлтийн хоцрогдол, суурь өвчлөлд хяналт тавьж, хүүхдийн зуны сувилал ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	Өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн тоо  Эрүүлжүүлэлтийн хувь	22  50	19  90
9.12	Өсвөр үеийн хүүхэд залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээ зохион байгуулж, охидын жирэмслэлтийг бодитоор бууруулах	Арга хэмжээний тоо  Охидын жирэмслэлтийн тоо	1  20	2  15
9.13	"Эрүүл чийрэг эр хүн" аян зохион байгуулж, цэргийн насын эрчүүдийг эмчлэн эрүүлжүүлэх	Үзлэгт хамрагдсан эрчүүдийн тоо  Эрүүлжүүлэлтийн хувь	85  50	200  70
9.14	"Жаргалтай амьдрал" СНСЗЭТ-ийн нэхэн сэргээх хөтөлбөрт хамруулах	Хамрагдсан иргэдийн тоо	0	3

1	2	3	4	5
<b>10.Хүний хөгжил, хүүхэд, гэр бүлийн салбарын хүрээнд</b>				
10.1	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг ажиллах нөхцөл боломжоор хангаж дэмжлэг үзүүлэх	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны тоо Дэмжлэгийн тоо	-	1 Гүйцэтгэлээр
10.2	Аж ахуйн нэгжүүдэд шинээр "Эцэг эхийн зөвлөл" байгуулж, бодлогыг хэрэгжүүлэх	Шинээр байгуулагдсан эцэг эхийн зөвлөлийн тоо  Хүүхэд хамгааллын бодлоготой аж ахуйн нэгжийн тоо	-	5 5
10.3	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57, 2025 оны 41 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хяналт тавих	Хяналт тавьж ажилласан уралдааны тоо  Бүртгэгдсэн уралдаанч хүүхдийн тоо  Бэртэл гэмтлийн хувь	3 25 2	1 25 0
10.4	"Хүүхдээ сонох өдөр"-ийн хэрэгжилтийг сайжруулах	Оролцогчдын тоо Саналын шийдвэрлэлтийн хувь	225 60	230 70
10.5	"Хүүхдийн нэгдсэн чуулган" зохион байгуулах	Оролцогчдын тоо Саналын шийдвэрлэлтийн хувь	120 60	130 70
10.6	"Би ирээдүйн баялаг бүтээгч" хүүхдийн экспо үзэсгэлэн зохион байгуулах	Экспо зохион байгуулсан тоо Оролцсон хүүхдийн тоо	- -	1 80
10.7	Хүүхдийг эрсдэлт урьдчилан нөхцөлд сэргийлж төлөвшил хүүхдийн сайруулах	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	136	136
10.8		Хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	8	30
10.9		Хөгжлийн үйлчилгээ (Секц, дугуйлан)-нд хамрагдсан зорилтот бүлгийн хүүхдийн тоо	130	150
10.10		Өвгөнжаргалант зусланг түшиглэсэн Хөдөлмөр зусланда хамрагдсан хүүхдийн тоо	5	5
10.11	Тогтвортой гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах	Шинээр гэрлэлтээ батлуулсан хосын тоо	5	Гүйцэтгэлээр
10.12		Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо Нийт өрхөд эзлэх хувь	698 59.9	700 60
10.13		Хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн төсвийн хэмжээ	11.0	3.0

1	2	3	4	5
10.14		Кейс шийдвэрлэлтийн хувь	100	95
<b>11.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд</b>				
11.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллах нэхцэлөөр хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, ажилгүй иргэдийн судалгааг гарган, ядуурлын түвшинг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх талаар оновчтой арга хэмжээ зохион байгуулж ажиллах, ерх бүрд ажлын байр бий болгох талаар дэмжиж ажиллах	Байнгын ажлын байраар хангагдсан иргэдийн тоо  Түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	22  0	25  20
11.2	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэн, Ахмадын өргөөг ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллах	Үйл ажиллагаа нь тогтмолжсон өргөө, танхимиын тоо  Дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ  Арга хэмжээнд хамрагдсан ахмад настны тоо	1  2.0  420	1  2.0  1230
11.3	“Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж, нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжид тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Ахмадын сан байгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн хувь  Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	-  -	60  30
11.4	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагчид ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо  Хамрагдсан ахмад настны тоо  Сурагчдын тоо	-  -  -	10  100  60
11.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл,	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь  Хамрагдсан иргэдийн тоо	-  -	90  350

1	2	3	4	5
	сурталчилгааны ажлыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх, шаардагдах хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, орон нутгийн жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган ажиллах	Дэмжлэгт үзүүлсэн хөрөнгийн хэмжээ	-	2.0
11.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо  Хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	2  180	4  381
11.7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нэхэн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалт зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нэхэн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмч, ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулах	Сургалтын тоо  Хамрагдсан иргэдийн тоо  Чадавхжуулсан эмч, мэргэжилтний тоо	-  -	10  100  5
11.8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Эцэг, эх асран хамгаалагчдын тоо  Хамтран ажилласан төрийн бус байгууллагын тоо	16  2	20  3
11.9	Төрийн үйлчилгээний байгууллагын гадна, дотор талын хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, саадгүй болгох	Хүртээмжийг сайжруулсан төрийн байгууллагын тоо  Үйлчилгээ авсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	-  -	6  300
11.10	Хүүхдийн төлөө зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Жендерийн дэд салбар хороо, Залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл, ХАБЭА-н салбар зөвлөл, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл, Хэлний бодлогын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн	Шийдвэрийн тоо  Хүүхэд, залуучуудын оролцооны түвшин  Ахмад настны оролцооны түвшин  Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцооны түвшин  Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	3  -  -  -  80	6  90  70  70  90

1	2	3	4	5
	бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагыг дэмжиж бодит оролцоог ханган, салбар дундын уялдаа холбоог сайжруулах	Тайлангийн тоо	-	2
11.11	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт төлөвлөж, хэрэгжүүлэх	Төсөвлөсөн мөнгөн дүн	-	3.0
11.12	Нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо Сайн дурын даатгалд хамруулсан малчдын тоо Хувираа хөдөлмөр эрхлэгч, оюутан запуучуудын тоо	2 476 186 21	2 827 201 25
11.13	Сумын ахмадын хорооны даргыг төрийн байгууллагуудын ахмадуудтай харилцах Үүрэгтэйгээр гэрээ байгуулж Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан ажиллуулж хагас бүтэн жилээр ажлыг үнэлэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж ажиллах	Хэрэгжилтийн хувь	0	100
<b>12. Жендерийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалтын хүрээнд</b>				
12.1	Аймгийн ИТХ-ын 2023 оны 12.05-ны өдрийн 17/78 дугаар тогтоолын сумд хамааралтай заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	80
12.2	Жендерийн дэд салбар хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавих	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	100
12.3	Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох	Хамрагдсан иргэдийн тоо	-	500
12.4	Сум, орон нутгийн бодлого төлөвлөлтэд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаарх заалт тусгах, төсөв хөрөнгө зарцуулах, дэмжин ажиллах	Зарцуулсан дэмжлэг Шинээр томилогдсон удирдлагуудыг цахим сургалтад хамруулсан хувь	-	1.0 100
12.5	Бүх нийтэд жендерийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн аян, арга хэмжээг хэрэгжүүлэх	Жендерийн Үндэсний хорооноос бэлтгэсэн цахим сургалт, мэдээллийг хүргэсэн иргэдийн тоо	-	1000

1	2	3	4	5
<b>13. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын хүрээнд</b>				
13.1	Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нөхцөл байдлын үнэлгээ хийж, хадгалалт хамгаалалтыг сайжруулан иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулах.	Үнэлгээ хийсэн дурсгалын тоо Гэрээгээр хамгаалуулсан дурсгалын тоо	- 6	1 7
13.2	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын анхдугаар чуулган уулзалт, зөвлөгөөнд өвлөн уламжлагчдаа оролцуулах	Чуулганд оролцсон өвлөн уламжлагчдын тоо	-	7
13.3	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах сургалтад үе шаттай хамрагдах	Мэргэжлийн боловсон хүчиний тоо	3	5
13.4	Соёл, урлагийн салбарт шилжин, суурьшин ажиллаж байгаа албан хаагчдыг дэмжиж ажиллах	Дэмжлэг үзүүлсэн албан хаагчдын тоо	1	2
13.5	"Соёлтой Баянхонгорчууд" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, соёлын үйл ажиллагааг өргөжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хамрагдсан хүний тоо	6 80 357	7 100 1300
13.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд, ахмад настан соёл урлагийн үйлчилгээ авах ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх	Гүйцэтгэлийн хувь	-	100
13.7	Соёлын орон зайн бүрдүүлж бүтээлч гудамж бий болгох /Street art/	Гүйцэтгэлийн хувь	-	100
13.8	Иргэд, олон нийт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх зориулалтын зам, талбайг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулах	Гүйцэтгэлийн хувь	-	100
13.9	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо Дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн иргэдийн тоо Хэвийн жинтэй иргэдийн тоо	14 712 70 96	18 900 100 130
<b>14. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, ашиг шимиийг нэмэгдүүлэх хүрээнд</b>				
14.1	Сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийг 3 орон тоогоор ажиллуулах	Тасгийн орон тоо	-2	-3

1	2	3	4	5
14.2	Аймгийн Засаг даргын тэтгэлгээр Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн чиглэлээр суралцаж буй суралцагчдын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Хяналтын тоо	-	-1
14.3	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийн хангах	-Өвс, тн	-50	-50
		-Тэжээл, тн	-30	-30
14.4	Тариалалтын хэмжээг нэмэгдүүлж 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах (нэгдүгээр хавсралтаар)	Тариалсан талбайн хэмжээ, га	-808	-869
		Хураан авсан ургац,тн	-2653	-3454
14.5	Атаршсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр арга хэмжээ авах	Судалгааны тоо	-	1
		Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн тоо	-	1
		Шинээр хийлгэсэн хөрсний шинжилгээний тоо	-	1
14.6	Өвөлжээ бууцны хөлд малын тэжээлийн ургамал тариалах	Нийт малчин өрхөд эзлэх хувь	-	-10%
14.7	Таримлын үрийн чанар, аюулгүй байдалд хяналт тавих	Хяналтын тоо	-	-2
14.8	Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Цагаан алт", хөтөлбөрийг сумын өрх бүрд хүргэж, сурталчлан таниулах	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Хамрагдсан хүний тоо	1 12951	2 300
14.9	"Шинэ хоршоо-чинээлэг малчин" хөдөлгөөн хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хоршооны тоо Зээлийн хэмжээ	1 - -	2 10 -
14.10	"Хүнсний хувьсгал", үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд хэрэгжүүлж ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2
14.11	"Атарын IV аян"-ыг хэрэгжүүлж ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2
14.12	Хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, ашиглалтгүй тоног төхөөрөмжийг эгүүлэн татах	Тоног төхөөрөмжийн тоо	823	823
14.13	Малын удмын санг хамгаалах, ашиг шим, үүлдэрлэг байдалд хяналт тавих	Хяналтын тоо	-	2
14.14	Малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор зохиомол хээлтүүлэг хийх ажлыг төлөвлөн шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг батлуулах	Батлагдсан хөрөнгийн хэмжээ (сая.төг)	-	20,0
14.15	Өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглалыг цаг агаарын мэдээнд тулгуурлан бодитой тогтоох, цаг агаарын	Даац тодорхойлох тоо	1	1

1	2	3	4	5
	аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилсан сэргийлэх мэдээг малчид, иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх, цаашдын бодлого төлөвлөлтэд тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Зураглал гаргах тоо	1	1
14.16	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах;	Эдийн засгийн эргэлтэд оруулсан малын тоо (мян.тол)	-	50,0
14.17	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	Шинээр гаргасан болон сэргээн засварласан худгийн тоо	2	3
14.18	Мал эмнэлгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зохион байгуулах;	Хамрагдсан малын тоо (сая.тол)	3.0	3.0
14.19	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устаха халдвартгүйтгэлийн ажлыг зохион байгуулах;	Сэг зэм устгалын хувь	100	100

#### 15.Хүнс, худалдаа үйлчилгээний салбарын хүрээнд

15.1	Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа, зээлийн зарцуулалтад хяналт тавих	Хяналтын тоо	-0	-4
15.2	Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, олгосон зээлийн мэдээллийг сар бүр шинэчилж олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх	Чанаргүй зээлийн бууралтын хувь	-20	-18
15.3	Нийтээр тэмдэглэх баяр болох Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жилээр хүнсний аюулгүй байдлыг хангуулах	Хяналтын тоо	-	-4
15.4	Сумдын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн орчны дэлгэрэнгүй судалгаа хийх	Судалгааны тоо	-0	-2
15.5	Сумдын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг үзэсгэлэн худалдаанд идэвхтэй, хариуцлагатай хамруулах	Үзэсгэлэн худалдааны тоо	-2	-3
15.6	Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх;	- Бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрлийн тоо	-	-3

1	2	3	4	5
<b>16. Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн хүрээнд</b>				
16.1	Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын саналыг багийн иргэдийн Нийтийн Хурал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах	Хэлэлцүүлэн батлуулсан саналын тоо	-	-1
16.2	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын тоо, Зөрчил шийдвэрлэлтийн хувь	-	-10, -100
16.3	Ус, усны сан бүхий газрын үхсэн малын сэг зэм, хог хаягдлын цэвэрлэгээ, устгал ариутгал халдвартгүүлэлтийн ажлыг улирал бүр зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-4
16.4	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Шинээр нэмэгдүүлсэн тэмдэгжүүлэлтийн тоо	-	-2
16.5	Гадаргын усны тоо бүртгэлийн ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	-	-100
16.6	Зэрлэг амьтны тархац нутаг малын бэлчээртэй давхацсан бүс нутагт мал, амьтны гаралтай халдварт өвчнөес сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-2
16.7	Ган, зуд, цаг үеийн нэхцэл байдлаас шалтгаалан зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлэх	Биотехникийн арга хэмжээний давтамжийн тоо	-	-2
16.8	Байгалийн нээц ашигласны төлбөрийн тухай хууль, дагалдах журмын хэрэгжилтийг хангаж, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэж нэмэгдүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	-100
16.9	Байгалийн нээц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалтыг Байгаль орчныг хамгаалах, нэхэн сэргээх арга хэмжээний төсөв зардлын мэдээллийн санд үнэн зөв төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах.	Цахим мэдээллийн санд оруулсан мэдээний тоо	-	7
16.10	Сар бүр бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	Зохион байгуулсан цэвэрлэгээний тоо	-	-12

1	2	3	4	5
16.11	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх ажлыг иргэд, байгууллагад хэвшүүлэх	Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ, тн	-	-200
16.12	Төвлөрсөн хог хаягдлын цэгийг хумъж цэгцлэх, камержуулах	Гүйцэтгэлийн хувь	-	-100
16.13	Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх	Нэмэгдүүлсэн ариун цэврийн байгууламжийн тоо	-	-15
16.14	Стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонг буулгах	Буулгасан нүхэн жорлонгийн тоо	-	-15
16.15	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг угтан сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг өргөн зохион байгуулж, иргэдэд экологийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх	Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь	-	-30
16.16	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд хамгаалалтын ойн зурvas байгуулах, мод тарих боломжит газрын судалгааг гарган 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган баттуулах	Шинээр сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан газрын тоо	-	-1
16.17	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ойжуулалт, ногоон байгууламжийн талбайн худаг, усалгааны асуудлыг шийдвэрлэх	Хэрэгжилтийн хувь	-	-100
16.18	Хавар намрын улиралд бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах	Тарьсан модны ургалтын хувь	-	-75
16.19	Ургамлын мониторинг судалгаа хийх	Хэрэгжилтийн хувь	-	-100

#### 17. Газрын харилцаа, дэд бүтцийн хүрээнд

17.1	Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэж, нэгж талбарт газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх	Газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн талбайн тоо	Гурванбулаг -2 Бөмбөгөр -6 Галуут -3	Баянговь-5
17.2	Газарт учруулсан хохирлын тайлан (ГНСТ-9 маягт)-аас маш хүчтэй доройтсон газрыг тодорхойлох,	Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээс маш хүчтэй доройтолд өртсөн талбайг болон нөхөн сэргээх талбайн хэмжээ	295.5га	Нөхөн сэргээх газрын хэмжээ

1	2	3	4	5
	нэхэн сэргээх ажлыг хөрөнгө гарган зохион байгуулах	талбай болон нэхэн сэргээх байршилтэй тодорхойлох	доройтсо н 295.5га газрын байршилтэй тодорхойлох	нэхэн сэргээх
17.3	Газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд тургэн шуурхай хүргэх зорилгоор ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг үйл ажиллагаандадаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах	Ухаалаг төхөөрөмжийн тоо	-	1
17.4	Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг хулээлгэж өгөх	Гүйцэтгэлийн хувь	-	100
17.5	Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	-	100
17.6	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан тайллагнах	Гүйцэтгэлийн хувь	-	100
